

## ОРЧИН ЦАГИЙН УТГА ЗОХИОЛЫН ХЭЛНИЙ АСУУДАЛД

Д.Оюунбадрах, П.Яньдий, МУБИС

## Abstract

Children's story must have clear and sharp composition which used the most lyric description of the language. Main goal of the children's author is to respect home language and should obtain higher knowledge of language. Therefore children's story should reflect and include clear composition, tuneful expression and sharp joke of the language. The classical examples of children's story are richly described in Mongolian folklore.

High strict requirements must be paid on writing and composition of the children's story. Children's story requires high responsibility and very hard work. It is very difficult to compose the children's story and cohere with linguistic requirements of children's story in adjusting to children's mind and intellectual development. It is wrong to insufficiently consider linguist composition of the children's story and attempt to write with few words for the children. For this incapacity, value of the children's story decreases and educating impact of story is loosened. Improving linguistic composition of the children's story is significant to writing and speaking skill of future people and play higher role in their language development. The children's authors and writers must strictly understand and respect this duty and responsibility and must attempt use classic and appropriate words.

## Түлхүүр үг

Эх хэлээ эрхэмлэх, утга зохиолын хэлний хэм хэмжээ, цэцэн цэлмэг, цэвэр тунгалаг, хөгжөөн наргиантай, хүүхдийн зохиол, дүр, яруу дүрслэл

Хэл гэгч хүн төрөлхтний соёлын хөгжлийн гайхамшигт том ололт гэдэгтэй хэн ч маргахгүй. Хэлгүйгээр үндэсний соёл үл оршино гэж ярьдаг нь ч үүний баталгаа мөн. Тиймээс ухаант мэргэд хэлийг ихэд үнэлж дүгнэсэн байх юм. Үүнээс дурдвал Германы гүн ухаантан М.Хайддегер “Хэл бол ахуйн ордон”, Оросын Ф.Достоевский “Хэл бол ард түмэн”, Францын зохиолч А.Камю “Миний эх орон бол франц хэл” гэжээ. Энэ ертөнцөд удам угсаа, соёл, зан заншлаараа ялгаа бүхий олон үндэстэн, ястан бий. Тэд цөм өөрийн эх хэлээ хайрлан дээдэлж, хамгаалан хүндэтгэсээр ирснийг дээр өгүүлсэн мэргэдийн үг нотлон харуулж байна.

Оросын суут эрдэмтэн М.В.Ломоносов “...Римийн эзэн хаан V Карл Испани хэлээр бурхантай, Франц хэлээр нөхөдтэй, Герман хэлээр дайсантай, Итали хэлээр бүсгүйчүүлтэй ярихад зохимжтой хэмээн ярьдаг байсан гэлээ. Хэрэв тэрбээр Орос хэлийг төгс төгөлдөр мэддэг байсан бол хэлсэн бүхнээ базан хэн бүхэнтэй ярьж болох хэл...” гэсэн болой. Учир юун гэвэл Орос хэлэнд Испани хэлний гайхамшиг, Франц хэлний уянгалаг, Герман хэлний хурц тод, Итали хэлний зөөлөн тунгалаг цогцолсон бөгөөд бас юмыг дүрслэн гаргахдаа хүчтэй баян төгс, Герек Латин хэлний товч тодорхой мөн чанар бүрэн шингэсэн ажээ. Тэгвэл манай их зохиолч

Д.Нацагдорж эх хэлээ:

“...Өсөхөөс сурсан үндэсний хэл

Мартаж болшгүй соёл

Үхтэл орших төрөлх нутаг

Салж болигүй орон...” (Д.Нацагдорж, 2009, х.5) хэмээн шүлэглэсэн байна.

Энэ бүхэн бол эх хэлээ эрхэмлэн дээдлэхийн ухаан их мэргэдээс гарч буйн баримт юм. Ингээд бодохлоор хэл гэгч зүгээр нэг хийсвэр үгэн бүрхүүл бус, соёлын үнэт зүйл бөгөөд түүнийг хайрлан хамгаалж бас хөгжүүлж явах нь тухайн хэлийг эзэмшигч ард түмний хүндтэй ариун үүрэг болох нь тодорхой байна.

Хэл гэгч хүн төрөлхтний харилцааны хэрэглүүр болон гарч ирсэн бөгөөд чухам энэ үүргээрээ л бидний соёлын хөгжилтөд асар их нөлөө үзүүлж ирсэн ба цаашид ч тийн нөлөөлөх үнэт зүйл мөн. Энэ тухай Швейцарын алдарт хэл шинжээч Фердинанд де Соссюр “...Алив хуудас цаас мөн чанараа алдаагүй үедээ яах аргагүй нэг зүйл мөн. Бас хоёр талтай. Үүн лүгээ нэгэн адил хэл, сэтгэхүй хоёр салигүй холбоотой авч хоёр өөр зүйл мөн.” хэмээн тайлбарлажээ. Энгийнээр ойлговол нохой хуцах, чоно улих нь зөн билиг байдаг бол хүн нэг үг дуугарахдаа л яах гэж ямар зорилготой хэлж буйгаа урьдчилан сэтгэж боддог онцлогтой.

\* ✉ yandii@msue.edu.mn

Халх хүн “Бод” гэж хэлэхийн тулд санаж сэдэх юм уу, тооны үйлдэл хийх тухайд сэтгэдэг бол буриад хүн өглөө босох тухайд санаагаа “Бод” хэмээн илэрхийлдэг. Нэг үндэстэн, хоёр ястан л хоёр өөр ойлголтоо нэг ижил үгээр илэрхийлж буй нь хэл сэтгэхүй хоёрын ялгааны энгийн жишээ мөн. Үүнийг өгүүлэхийн учир гэвэл өнөө үед хэлний гүйцэтгэх үүргийг зөвхөн харилцааны хэрэглүүр төдий бус өөр хэд хэдэн чиглэлээр авч үздэгийн нэг нь уран зохиолын хэл юм. Энэ тухайд профессор Ц.Сүхбаатар “... Аливаа улс үндэстний бичиг зохиолын хэлний хэм хэмжээнд нийцэн тохирч байгаа үг яриаг зөв гэдэг. Бичиг зохиолын хэлний хэм хэмжээ гэдэг нь хэлний хөгжлийн тодорхой нэгэн үед нийгэм олноороо хамгийн зөв гэж үлгэр жишээ болгон авч хэрэглэж байгаа хэлний тогтолцоо юм. Хэлний хэм хэмжээ нь зөв яриа бичлэгийг хамгаалан бэхжүүлж, бурууг хязгаарлан хориглодог. Хэл ярианы соёл нь ерөнхий соёлын нэгэн чухал хэсэг билээ. Ер нь хэрхэн ярьж бичиж байгаагаар нь тэр хүний оюуны хөгжлийн төвшин, сэтгэхүйн соёлын талаар ойлголт авч болдог байна.” хэмээн бичжээ. Энэ бол утга зохиолын хэлний тухайд хамгийн ойлгомжтой энгийн тодорхойлолт юм. Энд өгүүлснээс үзэхэд утга зохиолын хэл гэдэг тухайн үндэстний хэлнээс тэс өөр зүйл бус харин хамгийн зөв ончтой үлгэр жишээ болохуйцыг нь шилэн сонгож аваад хэм хэмжээ болгон тогтоохыг л хэлж байна. Тэр үлгэр жишээг ердөө л өөрийн ард түмний харилцан ярьж ойлголцдог үг хэллэгээс сонгон авдаг нь илт байна. Монголчууд бол мэргэн сэцэн ухаантай бөгөөд тэрхүү ухаанаа мөн л мэргэн сэцэн үг хэллэгээрээ илэрхийлдэг ард түмэн юм. Ингээд амьдралд байдаг тун энгийн жишээ авъя. Манай төрөл саданд нутаг орноороо “Жимзээ” хэмээн авгайлан хүндэлдэг нэг чавганц байлаа. Тэр хүн сургууль соёлоор огт яваагүй бөгөөд бичиг үсэг ч мэддэггүй нэгэн байв. Гэхдээ хэлдэг үг нь гайхамшигтай. Жишээ нь: “Нэг хүү нь дэлгүүрээс гутал худалдан авчээ. Хоёр хонолгүй ханзарчихаж. Энэ тухайгаа эхдээ хэлтэл Жимзээ “Тэгэлгүй яах вэ дээ хүү минь. Май гээд өгөхөд л ханзраад унахгүй бол хэндээ гэж бөхлөх билээ дээ” гэжээ. “Бас нэг хүү нь айлд орж суун, хүргэн болсон агаад тэдний хамаг л хар бор ажлыг хийж гүйцэлдүүлдэг байжээ. Нэгэн удаа, намрын хүйтэн борооноор малынхаа хойноос яваад ирэхгүй удахлаар эхнэр нь жаахан санаа зовсон аятай үг хэлжээ. Түүнийг сонссон Жимзээ “Яахав дээ! Энэ хүн, хүйтэн бороонд осгож үхвэл хүн нь надад онгойж, ажил нь танайд онгойх байгаа даа.” гэжээ. Эндээс харахад хачин гайхамшигтай оносон үгс, уран зохиолын хэллэг сонсогдож байгаа биз. Бас нэгэн

жишээ авъя. “Манайхны Амар гэж бас нэг хэцүү өвгөн байлаа. Эхнэр хүү хоёр нь нэг юманд явж ирээд, ийшээ яваад, тэрүүгээр ороод гэх мэтээр яриад байжээ. Түнийг сонссон өвгөн “Та хоёр баруун, зүүн, хойт, урд, гэдэг үгээ мэддэггүй улс юм даа” гэж хэлсэн гэдэг. Энэ мэт жишээ цөөнгүй бий. Үүнээс гадна Монголчууд үг сөргөхдөө хүртэл ямар ухаантай болохыг ам муруйсан хоёр хүн эвлэрэхдээ хэлдэг: “За хө, Бухын хүү мөөрч уулзаад мөргөлдөж тардаг. Хүний хүү хэрэлдэж эхэлсэн ч хэлэлцэж тардаг юм. Нэг сайхан тамхилчихъя.” гэдгээс илэрхий. Үүнээс харахад энгийн агаад цэгцтэй үг хэллэг утга зохиолын хэлний хэм хэмжүүр болдог бол нөгөө талаараа ардын ухааныг тухайн үеийн соёлтой, бичгийн хүмүүс нь шүүрэн авч ашиглаад ухамсартай бүтээлч ажиллагааныхаа үр дүнд бичгийн буюу утга зохиолын хэлний хэм хэмжээг тогтоодог байна. Энэ тухайд Профессор Ц.Сүхбаатар “Бичиг зохиолын хэл хөгжихдөө ардын ярианы хэлний олон өнгө аяст тулгуурладаг жамтайн зэрэгцээ тэр ардынхаа хэлнээс хамгийн үнэ цэнэтэй, яруу тунгалгийг нь шилэн шалгаруулж бэхжүүлдэг учиртай. Чухам ийм учраас хэм хэмжээ байхгүйсэн бол бичиг, зохиолын хэл ч гэж байж чадахааргүй билээ.” хэмээн бичжээ.

Монголчууд эртний бичгийн соёлтой ард түмэн болох тул ийм хэм хэмжээг мөн л эртнээс эхлэн тогтоож чадсан баялаг сайхан уламжлалтай. Үүнийг бид “Монголын Нууц Товчоо”- ноос эхлээд XX зуун хүртэл өвөг дээдсийнхээ бичиж туурвисан сонгодог уран зохиолын сонгодог хэлнээс төвөггүй мэдэж болно. Сонгодог бичгийн хэлний эл уламжлал XX зууны эхэн үеийн хувьсгалч сэхээтнүүд болох О.Жамъян, Ж.Цэвээн, Бат-Очир, Д.Нацагдорж, С.Буяннэмэх, Ц.Дамдинсүрэн нарын бичиг зохиолд ч уламжлагдан ирсэн нь бидний бахархал мөн.

1940-өөд оноос Уйгаржин монгол бичгийг Кирилл монгол бичгээр сольсон нь уламжлалт сонгодог бичгийн хэл найруулгын хэм хэмжээнд өөрчлөлт гарсан хэдий ч тэр үеийн соёлт сэхээтнүүд басхүү энэ шинэ бичигтээ тохирсон хэл найруулгын хэм хэмжээг буй болгоод мөрдөн биелүүлж ирсэн юм. Энэ хэм хэмжээ нь шинэ цаг үетэйгээ тохирсон орчин үеийн ярианы болоод бичгийн хэлийг ойртуулсан түүхэн зайлшгүй шаардлагаар гарч ирээд үүргээ гүйцэтгэсээр байгаа сайн зүйл юм. Гагцхүү эл сайн талыг эс анзаарсан буюу тийн анзаарахыг үл мэдэгчид, хий сэтгэлийн хөдлөлөөр хуучныг хамгаалах нэрээр шинийг хэт үгүйсгэн бас хэтэрхий их эрх чөлөө эрхэмлэснээс өмнө үеийн утга зохиолын хэлний хэм хэмжээ алдагдан юу ч биш холион

бантан болоод байгаа нь хэн бүхний нүднээ илт. Үүнд нөлөөлж буй хүчин зүйл нь бидний 70 гаруй жил баримталж ирсэн социалист реализмын аргыг шүүмжилж, өөр шинэ арга барилуудыг нэвтрүүлэх гэсэн эрмэлзэлтэй холбоотой. Энэ ч буруу зүйл огт биш бөгөөд цагийн жам, ертөнцийн хөгжлийн дагуу гарч ирсэн зүй ёсны үзэгдэл мөн болой. Энд нэгэн жишээг авахад сүүлийн арав гаруй жил хамгийн их дэлгэрлийг олж, танин мэдэхүйн салбарт ихээхэн анхаарал татаж буй шинжлэх ухааны нэгэн салбар болох Синергетикийн шинжлэх ухаан буюу шугаман бус шинжлэх ухааны үүднээс бол энэ ертөнцөд туйлын төгс зүй тогтол, нийтлэг хууль систем, эмх цэгц, дүрэм журам байхгүй эмх замбараагүй хаос чанар л байдаг гэдэг ойлголтын хамгийн тод илэрдэг үзэгдэл нь хэл, бүр уран сайхны хэл гэж үзэж байгаа юм. Энэ ч бас үндэстэй. Үүнийг бид туулийн хатдыг:

*“...Гэр нэвт гэгээтэй*

*Туурга нэвт туяатай гэх буюу*

*Цаашаа хараад хэвтэхэд нь*

*Цаад далайн жараахай тоологдом*

*Наашаа хараад хэвтэхэд нь*

*Наад далайн жараахай тоологдом..”*

гэсэн дүрслэл, ноён хутагт Данзанравжаагийн:

*“...Цогц биеийн дотроос*

*Цочмог цочмог санах нь*

*Цоожны өргөс адил...”* гэж бичсэн хийгээд Д.Нацагдоржийн:

*“...Мярс мярс майлсаар*

*Намайг чиглэсээр ирдэг..”* эсвэл нэрт яруу найрагч Б.Явуухулангийн:

*“Мөнгөн аяга шиг гараас чинь*

*Мөнхийн уснаас уух юмсан...”*

гэх зэрэг мөр бадгаас тодорхой харж болно. Энэ мэт утгын болоод хэлзүйн логик дүрмийг зөрчсөн стандарт бус буюу дээр өгүүлсэнчлэн хаос шугаман бус шинж нь үгийн урлагийн бүхий л бүтээлд илэрдэг түгээмэл зүй тогтол болох нь одоо нэгэнт тодорхой болжээ. Үүнийг бид хүлээн зөвшөөрсөөр ирсэн бөгөөд уран зохиолд үндэсний хэлний дүрслэх аргын бүх бололцоо, найруулгын бүхий л боломжийг ашиглах тухай номлосоор ирсэн нь үүний баримт мөн. Гэхдээ энэ бол уран зохиолын хэлийг дүрслэх арга боломжийн хувьд нэг зүйлд хязгаарлагдалгүй өргөн чөлөөтэй ашиглах тухайд ярьж буй болохоос биш улс орон даяар мөрдөх утга зохиолын буюу бичгийн хэлний найруулга зүйн хэм хэмжээг хэн ч хамаагүй дураараа зөрчин хаос болгож болно гэсэн үг огт биш юм. Харин үүнийг дутуу ухаарсан дураараа дургигчдын уршгаар өнөөгийн утга зохиолын хэлний хэм хэмжээ алдагдаад байгаад бид давын

өмнө анхаарал хандуулан нэн даруй засаж авах учиртайг олон жил ярьсаар байгаа боловч эдүгээ хүртэл цэгцэрсэн нь үгүй ажээ. Ийн алдагдахад нөлөөлж буй хүчин зүйлүүд гэвэл:

Нэгд: Хуучин онолдоо шүүмжлэлтэй хандаж шинийг эрэлхийлэхдээ ул суурьтай бүтээлчээр хандахын оронд сэтгэлийн хий хөөрлөөр дэврэх үйл ажиллагаа ноёлох хандлагатай байна.

Хоёрт: Утга зохиолын хэлний хэм хэмжээг нэгэнт нийгэм даяар мөрдлөг болгох ёстой тул дээрээс буюу төрөөс анхаарч хуульчлан зааж өгөх, түүний хэрэгжилтэд байнга хяналт тавих явдал бөгөөд ийн анхаарах аваас учраад буй энэхүү бэрхшээлийг бид хялбархан давж чадна гэдэгт үл эргэлзнэм. Уран зохиол бол үг хэлээр дүрээ бүтээдэг урлагийн нэгэн төрөл юм. Тийм учраас зохиолдоо дүрсэлж буй зүйлд тааруулан үг хэлээ оновчтой зөв сонгох, яруу сайхнаар найруулах гэгч зохиолчийн хөдөлмөрийн нэгэн чухал хэсэг бөгөөд тун нарийн чимхлүүр ажил болно. Энэ талаар эрдэмтэн судлаачдын сургасан бичсэн зүйл нэн олон. Уран зохиолын хэлэнд ингэж нягт нямбай хандах шаардлага хүүхдийн уран зохиолд бүр ч илүү хүчтэй гарч ирдэг байна. Яагаад гэвэл хүүхдийн тархи оюун гэгч цэв цэвэрхэн самбар шиг ариун тунгалаг байх бөгөөд түүн дээр нэгэнт бичигдсэн зүйл хэртэй бол арилдаггүй тэр чигээрээ тогтдог тул бага балчир хүүхдэд уран зохиолоор байтугай энгийн яриа хөөрөөгөөр ч хэрэггүй, илүү дутуу үгсийг хэлж болдоггүй учиртай. Тиймээс бид хүүхдийн зохиолын хэл, найруулгын тухай хангалттай ярилцаж шүүн хэлэлцэж ирсэн. Харин энэ бүхнийг хэрэгжүүлэх тухайдаа л зохиолчид маань янз бүрээр хандаж, алдаа дутагдал гаргадаг нь арилаагүй байна. Тэд өөрсдийгөө зөвтгөх гэхдээ хүүхдийн хэл гэж нэг ангид тусгай юм байдаг мэтээр тайлбарлахыг оролддог. Үнэн хэрэгтээ бол тийм биш бөгөөд хүүхдийн зохиолын хэл нь тухайн үндэстний хэлний хамгийн яруу сайхан уран дүрслэлийн арга хэрэглүүрийг авч ашигласан оновчтой, хурц, тод байхад оршино. Монголын хүүхдийн уран зохиол нь монгол хэлнийхээ л тансаг сайхныг ашиглана.

Хүүхдэд зориулан зохиол бичиж буй хүний нэг эрхэм зорилго бол эх хэлээ хүндлэн үзэж, сайтар эзэмших явдал мөн. Тийм болохоор хүүхдийн алив зохиол монгол хэлний яруу тунгалаг сайхан найруулга, үг хэлний сонсголон цэцэн цэлмэг, хурц тод хөгжөөн наргианыг эрх биш шингээсэн байх учиртай. Ийн сонгодог жишээ монгол ардын аман зохиолд элбэг бий.

Тухайлбал: “Унаганы магтаал”-д:

*“Урт сайхан зоотой*

*Уужим сайхан ташаатай  
Хөлдөө жороотой  
Хүзүүндээ молцогтой..”*

гэх зэргээр ямар ч илүү дутуу үггүйгээр унаганы гаднах байдлыг өхөөрдөж хөөрхөн шинжийг жинхэнэ монгол хүний сэтгэлээр монгол хүүхдийн санаанд нийцүүлэн илэрхийлэхийн хамт:

*“...Чонон хоёр чихтэй  
Цолмон хоёр нүдтэй...”*

гэх зэргээр энэ амьтны зарим төрхийг өөр бусад зүйлтэй жишин зураглаж, гаргаж буй санаагаа тодотгосон бол:

*“...Толгойгоороо тоглодог  
Тоосноосоо бусгадаг  
Сүүлээрээ тоглодог  
Сүүдэрнээсээ бусгадаг...”*

гэх зэргээр амьд хөдөлгөөн оруулан дүрсэлж ганц унага ч бус ерөөс эрх дураараа тонгочин наадаж буй гэнэн балчир нялх амьтны дүрийг урласан төдийгүй ард түмний бүтээсэн их аман зохиолоос суралцахын чухлыг энд харуулж байна.

Аман зохиолын хэлний ярууг ашиглан бичсэн нэгэн зохиолчийн шүлгийн тухай хоёр эрдэмтний дүгнэлтийг авч үзье. Л.Бадарчийн “Унага” хэмээх шүлэглэсэн үлгэрийн тухайд эрдэмтэн зохиолч Ш.Гаадамба “...Монгол хэлний яруу найруулга төгс уянга хөгжимтэй, цэцэн цэлмэг, цэвэр тунгалаг хөгжсөөн наргиантай хэлээр хүүхдийн зохиол бичигдсэн байх ёстой. Монгол хэлний яруу сонсголттой хүүхдийн чихийг дасгахын тулд энэ мэт яруу найргийн шижир гялалзсан уянгат сайхан шүлгийг хүүхдэд уншуулж байх хэрэгтэй. Уншуулахын тулд бичиж байх ёстой.” гээд:

*“...Унага замдаа  
Ууттай юмтай  
Учран золголоо  
Учрыг нь сонирхлоо  
Үргэж бусгаж  
Үнэртэж хөдөлгөж  
Олон янзаар*

*Оролдож үзлээ  
Ууттай тэр юм  
Урваж хөрвөөд  
Уран үгээр  
Уянгалж хэлсэн нь  
Санаагаар ирдэг  
Сайн амьтан  
Хэн гэдэг вэ  
Хэлээч нэрээ*

*Унага хариуд нь  
Унгалдаж хэлсэн нь  
-Унага би байна*

Уутанд хэн байна вэ? гэв  
Урваж хөрвөөд  
Уутат хэлсэн нь  
-Ахын чинь нэр  
Ачит бор  
Ууланд ганцаараа  
Яах гэж ингэж  
Яваа билээ? гэв...”

Энэ хэдхэн мөр шүлэгт гэнэн хонгор нялх амьтны дүр, чонын бачит хуурмаг дүр, нүдэнд ургаж харагдах шиг болно. Унаганы үргэж, бусгаж, үнэртэж, хөдөлгөж олон янзаар оролдож байгаа зэрэгт цовоо сэргэлэн хүүхдийн томоогүй, зүггүй байдал туссан мэт сэтгэгдэнэ. Ардын аман зохиолоос чухамхүү хүүхдийн байдалд тохируулан билэгтэй сайхан боловсруулсан нь даруй Л.Бадарч агсны “Унага” гэдэг энэ зохиол болно. Энэ зөвхөн шүлэг болсон төдий биш, чухамхүү яруу найраг, тэр дундаа хүүхдэд зориулсан яруу найраг болсон байна” гэжээ. Мөн шүлгийн тухай доктор Л.Түдэв “Л.Бадарчийн” “Унага” гэдэг шүлэглэсэн үлгэр сургуулийн өмнөх насныханд тохирох ер аль ч насны багачуудыг хамарч чадахаар болсон нь онцгой юм.

*“Буурал унагатай  
Саарал гүү байж  
Буурал унаганд аа  
Саарал гүү хэлж  
Ээжээсээ бүү хоцор  
Ижлээсээ бүү тасар  
Чогчиг аюултай  
Чоно аюултай  
Бор чононоос*

*Болгоомжил гэжээ”* хэмээн үлгэр эхэлнэ.

Үлгэр хэллэг эвтэйхэн цэвэр, ойлгомжтой товч болж чаджээ. Түүнчлэн хоёр хоёр үгээр эвлэгхэн хослон шүлэглэсэн нь бяцхан уншигчдад их тохиромжтой болжээ.

Хэрэв:

Буурал хөөрхөн унагаа дагуулсан  
Саарал гүү амьдарч байж гэжээ.

гэх мэтээр унжруулан шүлэглэе гэж бодвол болох байсан. Гэвч хүүхдэд юм хийж өгч байгаагаа бодоход ингэж болохгүй, сунжирч мөр нь уртадсан илүүдэл үг нь олшрохоороо нэмж хүчийг нь барах байсан. Бяцхан уншигчийн амьсгалын урт, зүрхний цохилтод тааруулан хийсэн юм шиг өвөрмөц сайхан чанартай энэ үлгэр уран санаа, утга агуулга, үйл явдал, үйлийн дарааллаар хүүхдийн зохиолын шаардлагад яв цав нийцсэн нь бахдалтай.

*“...Буурал унага  
Бухимдаж сандарч  
Уйлж гэнэ*



Уулын цуурай

Элэглэж гэнэ

Хайрт ээжийнхээ

Халамжит үгийг

Хайхарсан бол

Хаанаас ингэх вэ?

Унага гэмээ нь

Ухаарч гэнэ

Уйлаад яах вэ?

Уулын шившиг

Орилоод яах вэ?

Ойн шившиг...”

гэх мэтээр тун аятайхан уран зурагтай болжээ. Мөн үлгэрт муу талынхаа баатрыг муулан илэрхий хараасангүй, тэр ч байтугай гуайлсан нь ёж шоглолын авьяас бүхий бяцхан уншигчдын сэтгэлд улам ч зохистой ажээ.” хэмээн онцлон тэмдэглэсэн байна. Эндээс харахад хүүхдийн зохиолын хэл найруулгад ажил хэрэгч үр дүнтэй хатуу шаардлага хэрэгтэй ажээ.

Нэрт эрдэмтэн Д.Отгонсүрэн “Хүүхдийн зохиолын хэл гэгч үнэн хэрэг дээрээ хамгийн их хариуцлага, шаардлагатай, маш нарийн ажил мөн. Хүүхдийн нас биеийн онцлогт тохируулан хүүхдийн хэл яриагаар найруулах хүүхдийн зохиолын хэлний шаардлагад нийцүүлэх гэдэг тун ярвигтай. Хүүхдийн зохиолын хэл найруулгыг дутуу ухаарч хүүхдийн мэдмээр юм шиг цөөн үгээр биччихвэл хүүхдийн зохиолын хэл болох нь тэр гэж бодвол таашаарал болно. Тэгснээрээ хүүхдийн зохиолын үнэ цэнэ нь буурч, хэлний хүмүүжүүлэх мэдүүлэх нөлөө алга болно. Хүүхдийн зохиолын хэл найруулгыг сайжруулснаар маргаашийн бүтээн байгуулагчдын бичих ярих чадварыг дээшлүүлж, хэл яриаг нь боловсруулах үүргээ биелүүлнэ гэдгээ хүүхдийн зохиолчид ухамсарлах хэрэгтэй.” хэмээн бичжээ. Тэгвэл хүүхдийн зохиолын хэл найруулгад тавих өөр нэг шаардлага бол хүүхдийн нас сэтгэхүйн онцлогтой үг хэл нь тохирч байх явдал юм. Гурван настай, таван настай хүүхэд хотын болон хөндөөний хүүхэд сэтгэхүй, хэл ярианы хувьд эрс ялгаатай. Зохиолч хүн үүнийг гярхай ажиглан ялгалгүйгээр хүүхдийн гэсэн нэрийн дор ерөнхий дундаж хэлээр бичиж хэрхэвч болохгүй юм. Тухайлбал бага насны хүүхдэд зориулсан зохиолын үг хэллэгт зугаа наадам хөгжөөн наргиан давуу байж гэмээ нь тэдний огцом түргэн сэтгэц, хөнгөн хурдан хөдөлгөөн зэрэгт нийцэж байдаг. Дээр жишээ болгон авсан унаганы тухай магтаал шүлгүүд энэ шаардлагыг сайтар хангасан бүтээл болсон байна. Харин өсвөр насныхны хувьд инээд наргиан байх авч бодол, эргэцүүлэл уянгын талын дүрслэл зэрэгцэн орж ирэх жишээтэй юм. Үүнийг бид Д.Цэвэгмидийн “Болд Самбуу хоёр”

өгүүллэг, М.Чимидийн “Түүхээс олдсон хүү” туужийн баатруудын яриа зэргээс мэдэж болох билээ.

Хүүхдийн зохиолын үг хэллэг уран дүрийг гаргахын зэрэгцээ хэл яриаг нь хөгжүүлж байдаг давхар үүрэгтэй. Иймээс зохиолын болоод баатруудын үг хэлэнд аль болох сонгодог шилдэг тохирсон зөв үг хэллэгийг оруулахыг туйлаас эрхэмлэх ёстой. Ялангуяа бага насны хүүхдэд зориулсан бүтээлд энэ нь бүр онцгой бөгөөд учир нь энэ насныхан алив зүйлийг их дуураймтгай байдгийн дээр өөрийн хүндэтгэж явдаг эцэг эх, багш нарынхаа хэлсэн ярьсан, ном зохиолоос уншсан зүйлдээ ихэд итгэн тэр бүхнийг туйлын үнэн зөв хэмээн ойлгодог онцгой сэтгэхүйтэй байдаг. Иймээс гадаад үг, бүдүүлэг үг, этгээд үг зэргийг хүүхдийн зохиолд хэрэглэхээс аль болохоор татгалзах ёстой.

Хүүхдийн зохиолын хэл найруулга хүүхдийн хэрэглэдэг үгийн нөөцийг нь нэмэгдүүлж, шинэ сэргэг үг хэллэг олныг оруулж, тэр бүхнээ эх хэлнийхээ яруу сайхан найруулгын дүрэм журамд зохицуулсан өөсэвгүй байх учиртай. Шинжлэх ухааны хялбаршуулсан зохиол, үлгэр зэрэг олон төрөл нь чиглэл чиглэлээрээ хүүхдийн үгийн санг баяжуулж орчин тойрных нь үзэгдэл юмнаас эхлээд огторгуй сансар хүртэлх уужим орон зайн талаарх мэдлэгийг нь нэмэгдүүлэхэд тусалж байх ёстой. Энэ бол хүүхдийн зохиолын хэл найруулгын нэг шаардлага юм. Хүүхдийн буюу хүүхэд баатрын хэл яриа бол хүүхдийн зохиолын хэлний бас нэг онцлог мөн.

Хүүхдийн хэл гэж тусгай юм байхгүй тухай дээр өгүүлсэн. Гэвч хүүхдийн сэтгэхүйн өвөрмөц онцлогоос шалтгаалаад өвөрмөц сонин хэллэг гарч ирдэг. Энэ бол хүүхдийн зохиолын хэлийг бүрдүүлэх гол хүчин зүйл биш боловч анхаарвал зохих асуудлын нэг мөн. Түүнчлэн самоварыг мамавар, милиционер /цагдаа/-ийг улица-ийг /гудамж/ улиционер гэх зэргээр хэлдэг хүүхдийн этимлогийн тухай К.Чуковский “Хоёроос тав хүртэл” /От двух до пяти/ номдоо тодорхой бичсэн байдаг. Харин энэ бүхнийг хүүхэд л хэлсэн юм гээд уран зохиолын баатрын үг хэллэгт оруулаад байх нь тэр бүрий зохимжгүй. Өөрөөр хэлбэл тухайн баатрын хэл яриа хэдэн настай хэн гэгч болохыг илэрхийлж байх учиртай. “Хүүхдийн зохиолын баатруудын дүр, хэл яриагаар нь ялгарч байх учиртайг мартаж болохгүй. Хүүхдийн зохиол бичих гэж байгаа хүн зохиолдоо гарах хүүхдийн “биеийн байцаалыг” үнэн бодитой, дэлгэрэнгүй тодорхой гаргаж хэлэх ярих үггүй нь сайн төлөвлөх хэрэгтэй юм.

## Дүгнэлт

Орчин цагийн утга зохиолын хэл гэдэг нь тухайн үндэстний хэлнээс тэс өөр зүйл бус харин хамгийн зөв ончтой үлгэр жишээ болохуйцыг нь шилэн сонгож аваад хэм хэмжээ болгон тогтоохыг хэлдэг байна.

Энгийн агаад цэгцтэй үг хэллэг утга зохиолын хэлний хэм хэмжүүр болдог бол ардын ухааныг тухайн үеийн соёлтой, бичгийн хүмүүс нь авч ашиглаад ухамсартай бүтээлч ажиллагааныхаа үр дүнд бичгийн буюу утга зохиолын хэлний хэм хэмжээг тогтоодог байна.

Өнөөгийн утга зохиолын хэлний хэм хэмжээ алдагдахад хүргэсэн гол хүчин зүйлсийн нэг нь хуучин онолдоо хэт шүүмжлэлтэй хандаж, шинийг эрэлхийлэхдээ ул суурьтай бүтээлчээр хандахын оронд сэтгэлийн хий хөөрлөөр дэврэх үйл ажиллагаа ноёлох хандлагатай болсонтой холбоотой юм.

Орчин цагийн утга зохиолын хэлний салшгүй нэг хэсэг бол хүүхдийн утга зохиолын хэл юм. Тиймээс тухайн үндэстний хэлний хамгийн яруу сайхан уран дүрслэлийн арга хэрэглүүрийг авч ашигласан оновчтой, хурц, тод байх талаар хүүхдийн зохиолчид уран бүтээлээ туурвихдаа анхаармаар байна.

Хүүхдийн зохиолын хэл гэгч зохиолч уран бүтээлчдээс эх хэлний гүнзгий нарийн мэдлэг хийгээд нягт нямбай ажиллагаа шаарддаг нарийн чимхлүүр ажил тул зохиолчид баатруудынхаа үг хэлэнд аль болох сонгодог шилдэг тохирсон зөв үг хэллэгийг оруулах нь өнөөгийн утга зохиолын тулгамдсан асуудлын нэг мөн.

## Ашигласан материал

- Бадарч, Л. (1955). Унага. Улаанбаатар.  
 Нацагдорж, Д. (1996). Бүрэн түүвэр -3. Улаанбаатар.  
 (2005). Монголын уран зохиолын дээжис-108. Боть-28. Улаанбаатар.  
 Отгонсүрэн, Д. (1974). Уран зохиолын хэлний тухай. Улаанбаатар.  
 Отгонсүрэн, Д. (1973). Хүүхдийн зохиолын хэлний тухай. “Цог”сэтгүүл, Улаанбаатар.  
 Отгонсүрэн, Д. (1988). Хүүхдийн зохиолын хэл найруулгын тухай. Уран сайхны шүүмжлэл бодол эрэгцүүлэл. Улаанбаатар.  
 Отгонсүрэн, Д. (1988). Балчир насны хүүхдийн хэл яриаг. Улаанбаатар.  
 Оюунбадрах, Д. (1986). Хүүхдийн уран зохиолын дүр, дүрслэл. Улаанбаатар.  
 Оюунбадрах, Д. (1997). Монголын хүүхдийн уран зохиолын уламжлал, шинэчлэл.

Улаанбаатар.

- Оюунбадрах, Д. (2004). Хүүхдийн зохиолын өвөрмөц онцлогууд. Утга зохиол судлал. УБИС-ийн сэтгүүл. Улаанбаатар.  
 Оюунбадрах, Д. (2007). Хүүхдийн уран зохиол. I дэвтэр. Улаанбаатар.  
 Оюунбадрах, Д. (2008). Хүүхдийн уран зохиол. II дэвтэр. Улаанбаатар.  
 Сүхбаатар, Ц. (2015). Монгол хэлний найруулга зүй. Улаанбаатар.  
 Түмэнжаргал, З. (1982). Сургуулийн өмнөх насны хүүхдийн зохиолын хэл, найруулгын онцлог. /”Хүүхдийн хүмүүжил” сэтгүүл-3./ Улаанбаатар.  
 Чуковский, К. (2015). От двух до пяти. Москва